

СӨБ, ХҮҮХЭД ХАРАХ ҮЙЛЧИЛГЭЭНД ХҮҮХДЭЭ ХАМРУУЛСАН ЗАЛУУ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОЖ ЧАДАХГҮЙ БАЙГАА ШАЛТГААН

А.Солонго³⁶, Жендэрийн үндэсний шинжээч, МУИС, ШУС-ийн багш, доктор, профессор

Б.Оюундарь, судалгааны багийн ахлагч

С.Янжинлхам, Ч.Одончимэг, Ж.Адьяа, Ш.Ариунаа, Т.Бөртгөлжин, судалгааны багийн гишүүд

Хураангуй

Төрийн бодлого СӨБ-т хамрагдалтын түвшинд түлхүү чиглэж, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж байгаа нь сайшаалтай ч хүүхдээ харах асуудал залуу эмэгтэйчүүд эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож чадахгүй байгаа хамгийн гол шалтгаан хэвээр байна. СӨБ, хүүхэд харах үйлчилгээнд хүүхдээ хамруулсан залуу эмэгтэйчүүдийн эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож чадахгүй байгаа учир шалтгааныг тодорхойлон, бодит байдлыг дүрслэн харуулахад энэхүү кейс судалгааны зорилго оршино. Судалгаанд чанарын судалгааны арга зүй ашигласан.

Ажил-гэр-цэцэрлэгийн хоорондын зай, нийтийн тээврийн хүртээмжгүй байдал, замын түгжрэл нь эмэгтэйчүүдийн ажил эрхлэх боломжийг хязгаарлаж байна. Цэцэрлэг, хүүхэд харах үйлчилгээний чанарыг сайжруулахгүйгээр тэдгээрт хамрагдаж буй хүүхдүүдийн дунд тархаж буй халдварт өвчний түвшин, давтамжийг бууруулах боломжгүй байна. Шинээр дагаж мөрдөж буй хөдөлмөрийн хуулийн холбогдох заалтыг нарийвчлан хэрэгжүүлэх, зөрчил гарсан тохиолдолд гомдол барагдуулах механизмыг бий болгон ажиллах чиг үүргийг ажил олгогчид, ажиллагсдын эрх ашгийг хамгаалах төлөөлөл, байгууллага /үйлдвэрчний эвлэл, жендэрийн зөвлөл, эмэгтэйчүүд, эцэг эхийн зөвлөл гэх мэт/-уудтай хамтран хэрэгжүүлэх, хянах, тайлагнах шаардлагатай байна.

Түлхүүр үгс: Цэцэрлэг, хүүхэд харах үйлчилгээ, үйлчилгээний чанар, хүртээмж, стандарт, хөдөлмөрийн гэрээ, ажил-гэр-цэцэрлэгийн хоорондын зай, нийтийн тээврийн хүртээмж, замын түгжрэл

REASONS FOR THE INABILITY TO PARTICIPATE IN ECONOMIC ACTIVITIES OF YOUNG WOMEN WHO HAVE CHILDREN IN CHILDCARE SERVICES

Abstract

It is commendable that the government policy focuses more on the level of participation in early childhood education and implements relevant measures, yet the problem of taking care of children remains the main reason why young women cannot participate in economic activities. The purpose of this case study is to identify the reasons for the inability of young women to participate in economic activities and to describe the reality of their child's participation in social services and child care services. Qualitative research methodology was used for the study.

The distance between work-home-kindergarten, lack of access to public transportation, and traffic congestion limit women's employment opportunities. Without improving the quality of kindergartens and child care services, it is impossible to reduce the level and frequency of communicable diseases among children attending them. It is imperative to implement the relevant provisions of the new labor law in detail and to create a grievance mechanism for addressing grievances in case of violations in cooperation with representatives and organizations /trade unions, gender councils, women's councils, parents' councils, etc./ to protect the interests of employers and employees for collective implementation, monitoring and reporting.

Key words: Kindergarten, childcare, service quality, availability, standards, labor contract, work-home-kindergarten distance, access to public transport, traffic congestion

³⁶ Холбоо барих зохиогч. Хаяг: solongo_a@num.edu.mn

1. УДИРТГАЛ

Үндэслэл

Монгол Улсын нийт 3.2 сая хүн амын 50.9 хувь нь эмэгтэйчүүд бөгөөд тэдгээрийн тал нь нөхөн үржихүйн насныхан юм. Нийт хүн амын 13.8 хувийг 0-5 насны хүүхдүүд (эдгээрийн 48.7% нь охид) эзэлж байгаа³⁷ бөгөөд бага насны хүүхдийн асран хамгаалал болон сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний хүрэлцээ нийгмийн тулгамдсан асуудлын нэг болсон. 1990 оноос хойш хотжилт маш эрчимтэй явагдаж байгаа ба тооцоогоор 2030 он гэхэд нийт хүн амын 78.6 хувь төвлөрсөн хот, суурин газар амьдрах төлөвтэй байгаа³⁸ нь боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдлыг улам бүр хүндрүүлэхээр байна.

Нөгөө талаас эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин (53.3%) эрэгтэйчүүдийнхээс (66.7%) нэлээд доогуур байсаар ирсэн бөгөөд төрөлтийн түвшин нэмэгдэхийн хэрээр эмэгтэйчүүдийн хөдөлмөр оролцооны түвшин буурсаар байна. Хүүхэд төрүүлэх, асрах, харах, гэрийн ажил хийх зэрэг нөхөн үржихүйн үүргээс шалтгаалан олон залуу эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээлийн гадна үлдсэн хэвээр байна³⁹. Асаргаа шаардлагатай гэр бүлийн гишүүдийг асрах цалин хөлсгүй хөдөлмөрт эмэгтэйчүүдийн зарцуулдаг цаг эрэгтэйчүүдийнхээс даруй 2.1 дахин их байна⁴⁰. Эрэгтэйчүүд гэр орны цалин хөлсгүй ажилд өдөрт 117 минут зарцуулдаг бол эмэгтэйчүүд дунджаар 281 минутыг зарцуулж байна⁴¹. Бага насны болон олон хүүхэдтэй эмэгтэйчүүдийн хувьд хүүхэд асрах үйлчилгээ болон цэцэрлэгийн хүртээмж, хүрэлцээ муу байгаа нь тэдний эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох боломжийг хязгаарлаж байна.

Монгол Улсын Засгийн газраас 2016 онд даян дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилтуудын

хүрээнд “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” батлан⁴², хүүхэд бүрийг стандартын шаардлага хангасан сургуулийн өмнөх боловсрол (СӨБ)-д хамруулах зорилтыг дэвшүүлж, СӨБ-ын тогтолцооны төрөл хэлбэрийг өргөтгөн сайжруулснаар 2030 он гэхэд СӨБ-ын үйлчилгээнд сургуулийн өмнөх насны нийт хүүхдийн 90 хувийг хамруулж, нэг багшид ногдох хүүхдийн тоог 20 хүртэл бууруулсан байх томоохон амлалтуудыг тусгасан байв. Энэ бодлогоо 2020 оны 5 сард хүчингүй болгож, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг⁴³ баталсан. Уг бодлогын “Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцооны шинэчлэлийн үе шат (2021-2030)”-нд СӨБ-ыг хүүхдийн төлөвшил, хөгжлийн суурь үе хэмээн үзэж, цэцэрлэгийн үйлчилгээний болон сургалтын чанарыг сайжруулахад чиглэсэн цогц үйл ажиллагааг зохион байгуулах зорилтыг дэвшүүлсэн байна.

Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль (2008, 2016)⁴⁴ -иар, бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих, сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж, боловсролын стандартыг⁴⁵ үндсэн болон хувилбарт сургалтаар хэрэгжүүлж байна. Түүнчлэн, 24 цагийн цэцэрлэг болон 1-3 цагаар уртасгасан, богиносгосон цагийн бүлгүүдийг эцэг, эх, асран хамгаалагчийн хүсэлтээр ажиллуулж байна. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн санхүүжилтээр төлбөртэй цэцэрлэг ажиллуулах боломжийг хуулиар хамгаалсан. СӨБ-ийн үйлчилгээг илүү хүртээмжтэй болгохын тулд баг, хорооны нутаг дэвсгэрт цэцэрлэг өөрийн салбараа байгуулан ажиллуулах боломжтой. 2022-2023 оны хичээлийн жилд нийт 1,413 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байгаагийн 68.6% нь төрийн өмчийн, 30.3% нь хувийн өмчийн, 1.1% нь орон нутгийн өмчийн цэцэрлэгүүд байна.

³⁷ NSO. (2021). Population, Statistical Database updated 22 April, 2021

³⁸ UNHABITAT. (2019). Urbanization, <https://ourworldindata.org/urbanization>

³⁹ YCX, Мэдээллийн нэгдсэн сан, <https://1212.mn>

⁴⁰ ЭЗХАХБ. (2019). Нийгмийн институци ба жендэрийн индекс. Retrieved from www.genderindex.org

⁴¹ YCX. (2020). Цар тахлын бизнесүүдэд үзүүлж буй нөлөө, 2-р шат. Улаанбаатар: Үндэсний статистикийн хороо

⁴² Монгол улсын их хурлын 2016 оны 2 сарын 5-ний өдрийн 19 дүгээр тогтоолоор

⁴³ Монгол улсын их хурлын 2020 оны 5 сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор

⁴⁴ Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийг 2008 онд баталж, 2016 онд шинэчилсэн. 2021 онд Боловсролын тухай багц хуулийг дахин шинэчлэн боловсруулж, УИХ-д өргөн барьсан.

⁴⁵ Боловсролын тухай хуулийн 11.3-т

Төрийн өмчийн цэцэрлэгүүдийн 70 орчим хувь нь хөдөө, орон нутагт (21 аймгийн төв, сумд), харин хувийн өмчийн цэцэрлэгийн дийлэнх (84.1%) нь Улаанбаатар хотод байршиж байна⁴⁶.

Ийнхүү төрийн бодлого СӨБ-т хамрагдалтын түвшинд түлхүү чиглэж, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж байгаа нь сайшаалтай боловч хүүхдээ харах асуудал залуу эмэгтэйчүүд эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож чадахгүй байгаа хамгийн гол шалтгаан хэвээр байна.

Судалгааны асуудал: Залуу эмэгтэйчүүд СӨБ, хүүхэд харах үйлчилгээнд хүүхдээ хамруулсан ч яагаад эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож чадахгүй байна вэ?

Зорилго, зорилтууд

СӨБ, хүүхэд харах үйлчилгээнд хүүхдээ хамруулсан залуу эмэгтэйчүүдийн эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож чадахгүй байгаа учир шалтгааныг тодорхойлон, бодит байдлыг дүрслэн харуулахад энэхүү бичил кейс судалгааны зорилго оршино.

Судалгааны үндсэн зорилгын хүрээнд дараахь зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

- 1) Бага насны хүүхэдтэй эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн хууль эрх зүйн орчинг тодорхойлох;

- 2) СӨБ, хүүхэд харах үйлчилгээнд хүүхдээ хамруулсан залуу эмэгтэйчүүдийн эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож чадахгүй байгаа учир шалтгааныг кейсээр нотлон харуулах;

- 3) Кейсийн нотолгоонд тулгуурлан залуу эмэгтэйчүүдийн эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох боломжийг нэмэгдүүлэх санал зөвлөмж боловсруулах.

2. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

2.1 Судалгааны загвар


Судалгаанд чанарын судалгааны арга зүй, загварыг ашигласан. Сэдвийн хүрээ, зорилгод нийцүүлэн шинжилгээний нэг нэгж ба олон кейсийн нэгжүүдийн судалгааны дизайныг сонгосон.

Кейсийн нэгж нь улсын болон хувийн цэцэрлэг, хүүхэд харах үйлчилгээнд хүүхэд нь хамрагдаж чадсан ч ажил эрхлэлтээ зогсоосон залуу эмэгтэйчүүд буюу хувь хүн байна.

2.2 Дүн шинжилгээний хүрээ ба таамаглал

Судалгааны багийн гишүүд бид асуудлыг тодруулах хэлэлцүүлэгт үндэслэн судалгааны дүн шинжилгээний агуулгажилтын хүрээг дараах байдлаар боловсруулсан (Бүдүүвч 1).

Бүдүүвч 1. Дүн шинжилгээний агуулгын хүрээ



⁴⁶ Боловсролын статистик, 2022-2023 оны хичээлийн жил

Таамаглал:

H₁: Ажил-гэр-цэцэрлэгийн хоорондын зай, нийтийн тээврийн хүртээмжгүй байдал, замын түгжрэл нь эмэгтэйчүүдийн ажил эрхлэх боломжийг хязгаарладаг.

H₂: Хүүхэд их өвддөг учраас ажлын чөлөө их авч ажил хийх боломжгүй болгодог.

H₃: Ажил олгогчийн зүгээс хөдөлмөрийн уян хатан нөхцөл бүрдүүлж өгдөггүй учраас хуулиар олгогдсон эрхээ эдэлж чадалгүйгээр ажлаа орхидог.

2.3 Кейсийн сонголт

Судалгаанд хамрагдсан кейсүүдийг анхдагч нэгжээр сонгосон (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Судалгааны нэгж, түүврийн хэмжээ

Судалгааны анхдагч нэгж		Тоо
1. Бага насны хүүхэдтэй ажил эрхэлж байгаад больсон эмэгтэйчүүд		4
1.1	СӨБ, хүүхэд харах үйлчилгээнд хүүхэд нь хамрагддаг /хотын төв-1, хотын зах-1/	2
1.2	СӨБ, хүүхэд харах үйлчилгээнд хүүхэд нь хамрагдаж байгаад больсон /хотын төв-1, хотын зах-1/	2
2. Гол мэдээлэгчтэй хийх ганцаарчилсан ярилцлага		2
2.1	Ажил олгогч /хувийн хэвшил/	1
2.2	Ажил олгогч /төрийн байгууллага/	1
Нийт		6

2.4 Мэдээлэл цуглуулалт

Мэдээлэл цуглуулах ажлыг 2023 оны 1 дүгээр сарын 19 – 2023 оны 1 дүгээр сарын 23-ны хооронд Улаанбаатар хотод зохион байгуулсан.

Гол кейсээр одоо ажил эрхлэхгүй байгаа хотын төв болон хотын захад амьдардаг, хүүхэд нь цэцэрлэг/хүүхэд харах үйлчилгээнд хамрагдсан 2, хамрагдахаа больсон 2, эмэгтэйг сонгосон. Эдгээр эмэгтэйчүүдийн хүүхдүүдийн 3 нь улсын өмчийн цэцэрлэгт, 1 нь хүүхэд харах үйлчилгээнд хамрагдаж байсан. Үйлчилгээний салбарт ажил олгогч 1, төрийн албаны удирдах ажилтан 1 хүнтэй ганцаарчилсан ярилцлага хийсэн.

3. БАГА НАСНЫ ХҮҮХЭДТЭЙ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖСЭН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улсын Үндсэн хууль (1992), Хөдөлмөрийн тухай хууль (шинэчилсэн найруулга 2021), Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011), Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль (2008), Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль (2015) зэрэг хуулиуд, Алсын хараа 2050, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого (2020), Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2020-2024 зэрэг хөгжлийн бодлого, төлөвлөгөөнүүдэд

бага насны хүүхэдтэй эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг хадгалж, хамгаалах эрх зүйн орчинг бүрдүүлж өгсөн байна. Тодруулбал:

- Монгол Улсын Үндсэн хуульд, хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна. Хуулийн 16.4-д ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй гэж заасан.
- Хөдөлмөрийн тухай шинэ хуульд:

88 дугаар зүйл. Шөнийн цаг.

88.5. Жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй ажилтан өөрөө зөвшөөрөөгүй бол шөний цагаар ажиллуулахыг хориглоно.

91 дүгээр зүйл. Илүү цагаар ажиллуулах.

91.4. Жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй ажилтан өөрөө зөвшөөрөөгүй бол илүү цагаар ажиллуулахыг хориглоно.

135 дугаар зүйл. Жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх /ганц бие эцэг/-ийн хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлахыг хориглох

- о 135.1.Энэ хуулийн 80.1.4, 80.1.5, 80.1.6-д заасан болон аж ахуйн нэгж, байгууллага татан буугдсанаас бусад тохиолдолд жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх /ганц бие эцэг/-ийн хөдөлмөр эрхлэлтийн харилцааг ажил олгогчийн санаачилгаар цуцлахыг хориглоно.

139 дүгээр зүйл. Хүүхэд асрах чөлөө олгох

- о 139.1. Гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, эцэг өөрөө хүсэлт гаргасан бол ажил олгогч түүнд хүүхэд асрах чөлөө олгох бөгөөд энэ хугацаанд тэтгэмж олгох асуудлыг холбогдох хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр зохицуулна.
- о 139.2.Хүүхэд асрах чөлөө нь дууссан, эсхүлдусаагүй боловч ажилтан хүсэлт гаргасан бол ажил олгогч түүнийг ажлын байранд нь үргэлжлүүлэн ажиллуулах үүрэгтэй бөгөөд хэрэв орон тоо нь хасагдсан, ажилтны тоог цөөрүүлсэн бол адил чанарын өөр ажлын байранд ажиллуулна.
- о 139.3. Энэ хуулийн 139.1, 139.2-т заасан нь хүүхэд үрчлэн авсан ажилтанд нэгэн адил хамаарна.

140 дүгээр зүйл. Жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй ажилтныг уян хатан нөхцөлөөр ажиллуулах

- о 140.1.Жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй ажилтан ажил үүргээ гэрээсээ, эсхүл зайнаас гүйцэтгэхээр ажил олгогчтой харилцан тохиролцож болно.

141 дүгээр зүйл. Албан томилолтоор ажиллуулахыг хориглох

- о 141.1.Жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй ажилтныг өөрөө зөвшөөрснөөс бусад тохиолдолд албан томилолтоор ажиллуулахыг хориглоно.

- Сургуулийн өмнөх боловсролын хуульд:

- о 7.2.Сургуулийн өмнөх боловсролд хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны бүх хүүхдийг хамруулна.

- о 8.3.Цэцэрлэг нь сургуульд элсэхийн өмнөх насны бүх хүүхдэд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг хүргэж, сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангана.

- о 9.7.Цэцэрлэг нь эцэг, эх, асран хамгаалагчийн санал, хүсэлтэд үндэслэн Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 8.7, 8.8, 8.9, 8.10-т заасан нөхцөл бүрдсэн тохиолдолд хоёр хүртэлх насны хүүхдийг асрах, хамгаалах, хөгжүүлэх үйлчилгээ үзүүлж болно.

- о 12.6.Эцэг, эх, асран хамгаалагчаас шалтгаалан багш илүү цагаар ажилласан тохиолдолд эцэг, эх, асран хамгаалагчаас төлбөр авах асуудлыг цэцэрлэгийн зөвлөлийн шийдвэр, эцэг, эх, асран хамгаалагчтай байгуулсан гэрээний дагуу зохицуулна.

- Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд:

5 дугаар зүйл. Хүүхэд харах үйлчилгээнд хамрагдагч

- о 5.1. Хүүхэд харах үйлчилгээнд хоёр наснаас ерөнхий боловсролын сургуульд элсэх хүртэлх насны хүүхэд хамрагдана.

- о 5.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нас харгалзахгүйгээр хүүхэд харах үйлчилгээнд хамруулж болно.

- Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд эмэгтэйчүүдийн амьдралын чанарыг дээшлүүлэхтэй холбоотойгоор боловсрол, эрүүл мэнд, гэр бүл, амьдрах ээлтэй орчин, хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдлыг сайжруулах шинэчлэлүүдийг эхлүүлэхээр тусгасан. Хөдөлмөр эрхлэлт, бүтээлч санаачилга, хандлага болон ур чадварыг хөгжүүлэх, аж ахуй эрхлэлтийг дэмжсэн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2020-2024)-т эмэгтэйчүүдийн амьдралын чанартай холбоотой дараах заалтуудыг тусгасан. Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлэх зорилгоор яслийн

үндэсний тогтолцоог сэргээж 1-2, хүүхэд харах үйлчилгээнд 2-3 насны хүүхдийг хамруулж, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ гэсэн заалтуудыг тус тус тусгасан байна.

4. СӨБ, ХҮҮХЭД ХАРАХ ҮЙЛЧИЛГЭЭНД ХҮҮХДЭЭ ХАМРУУЛСАН ЗАЛУУ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОЖ ЧАДАХГҮЙ БАЙГАА УЧИР ШАЛТГААН

4.1 Боломж ба хүртээмж

2022 оны байдлаар СӨБ-ын хамран сургалтын түвшин 87.6%, сургуульд элсэхийн өмнөх буюу 5 настангуудын хамран сургалт 92.1%-д хүрсэн байна. Гэвч улсын болон хувийн хэвшлийн, хот болон хөдөөгийн цэцэрлэгүүдийн үйлчилгээний хүртээмж, чанар ялгаатай, малчид, ядуу, эмзэг бүлгийн өрхийн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд СӨБ-ын үйлчилгээг эрх тэгш хүртэх боломж хомс хэвээр байна.

Цэцэрлэгийн нэг бүлэгт 1 багш, 1 туслах багш, 20-25 хүүхэдтэй байхаар СӨБ-ын үлгэрчилсэн дүрэмд заасан боловч стандартаас хол давсан ачаалалтай ажиллаж байна. Тодруулбал, Бодит байдал дээр⁴⁷ бүлэг дүүргэлт дунджаар улсын хэмжээнд 30, аймгийн төвд 30.7, Улаанбаатарт 30.3, сумын төвд 29.0, багийн төвд 26.4 байна.

Цэцэрлэгийн хүртээмжгүй байдлаас үүдэн зөвхөн хотод төдийгүй хөдөөгийн цэцэрлэгүүдэд бүлэг дүүрэлт 40-45 түүнээс ч олон хүүхэдтэй, бараг 2 дахин их ачаалалтай үйлчилгээ үзүүлж байна гэсэн үг юм.

Хэдийгээр хүүхдийн цэцэрлэгийн тоо нэмэгдэж байгаа ч хүн амын нягтрал хамгийн өндөр хот, суурин газруудад ялангуяа Улаанбаатар хотод цэцэрлэг хүрэлцээгүй хэвээр байна. Хотод танилын хүрээ бага, мэргэжилгүй, боловсрол багатай, амьжиргааны түвшин доогуур, гэр хорооллын, хотын төвөөс алслагдсан өрхийн хүүхдүүдийн цэцэрлэгт хамрагдалтын түвшин доогуур байна. Цэцэрлэгийн хүртээмжгүй байдлаас үүдэн ялангуяа хотын өрхүүд өөрийн амьдарч буй харьяа хорооныхоо цэцэрлэгт хүүхдээ өгч чадахгүй байна. Өнөөдөр хүн амын төвлөрөл

их хотын хороодын хүүхдүүдийг оршин суудаг харьяа цэцэрлэгийн анги дүүрсэн тохиолдолд зэргэлдээх хороодын цэцэрлэгт хамруулах арга хэмжээг авч байна.

Ажил-гэрийн хоорондын зай хол байдаг хүмүүсийн хувьд хүүхдийн цэцэрлэгийн байршил хамгийн чухал байна. Ажил эрхэлдэг эцэг эхчүүд хүүхдээ аль болох ажлын газрынхаа ойролцоох цэцэрлэгт хамруулахыг хичээж байна. Учир нь цэцэрлэгт хүүхдээ өгөх хугацаа өглөө 7.30-9.00, орой авах хугацаа 16.30- 5.30 цаг байдгаас ажлын цаг дуусаагүй байхад хүүхдээ авах боломжгүй эцэг эхчүүдэд илүү бэрхшээлтэй байна. Үүнээс гадна хүүхдийн цэцэрлэг, сургууль эхлэх болон тарах үед авто замын түгжрэл хэрээс хэтэрдэг явдал давхар нөлөөлж байна. Хэдийгээр өөрийн оршин суугаа харьяа цэцэрлэгт хүүхдээ өгдөг ч ялангуяа гэр хорооллын хүүхдүүд цэцэрлэгтээ очих, гэртээ ирэхэд хамгийн багадаа 30 минут зарцуулдаг, түгжрэл ихтэй үед 2 цаг зарцуулах тохиолдол байдаг талаар чанарын судалгаанд оролцсон ээжүүд онцолж байна. Хүүхдээ тарах цагт нь авч амжихгүй тохиолдолд гэр бүл, найз нөхдөөсөө тусламж голдуу авдаг, бүр боломжгүй бол багш руу утасдаж цэцэрлэгийн жижүүр дээр үлдээлгэх зэргээр зохицуулж байна. Харин нийгмийн хүрээлэл муу, ам бүл цөөхөн эцэг, эхчүүдийн хувьд ажлаасаа эрт тарах, ажилдаа ойрхон цэцэрлэгт хүүхдээ явуулах, ажил дээрээ хүүхдээ байлгаж цагийн зохицуулалт хийдэг ажээ. Тусгай хэрэгцээт цэцэрлэг цөөхөн, орон тоо хүрэлцдэггүйгээс заавал танил талаар яриулж, хөөцөлддөг, арай гэж цэцэрлэгт оруулсан болохоор гэрээ цэцэрлэгт нь ойртуулж нэг дүүргээс, нөгөө рүү шилжин суурьших шаардлагатай болдог байна.

- Бага насны хүүхэддээ цэцэрлэг, сургуульд хүргэж өгөх, авахад маш их цаг зарцуулдаг. Ялангуяа цэцэрлэг, сургуулийн аль алинд хүүхдүүд нь хамрагдаж буй тохиолдолд цагийн менежент хийх боломжгүй байдаг байна.

...Манайх 8 настай, 5 настай, 2 сартай 3 хүүхэдтэй. Бид БГД дүүрэгт амьдардаг. Гэрээс хүүхдийн цэцэрлэг хүртэл 3 кт, хүүхдийн сургууль хүртэл 3 кт зайтай. Сургууль цэцэрлэг хоорондоо 5 км зайтай. Би өглөө 7:00-д гэрээсээ гараад алхаад хүүгээ цэцэрлэгт нь хүргэж өгөөд, хариад

⁴⁷ Statistical news of the preschool education sector, meds.gov.mn/post/64832

охиноо өдөр сургуульд нь хүргэж өгдөг. Орой цэцэрлэгээс хүүгээ авчихаад охиноо сургуулиас нь авна. Манай хүү, охин 2-ын сургууль цэцэрлэг автобусаар очиход төвөгтэй. Яг 2 буудлын дунд байдаг болохоор буудал руу алхаж суугаад нэг буудал явснаас алхсан нь шулуун байдаг. Ирж

очиход 1 цаг орчим болдог доо. Орой бас цэцэрлэг сургуулиас нь аваад нэг цаг орчим алхаад ирнэ. 18:00 гэхэд гэртээ ирнэ...(Өдрийн маршрутын зураглалыг дор харуулав).

Маршрут	Зай	Тээвийн хэрэгсэл	Хугацаа	Зарцуулж буй цаг	Нийт цаг
Гэр - Цэцэрлэг	3 км	Алхдаг	07:00-08:20	1 цаг 20 минут	4 цаг 20 минут
Гэр - Сургууль	2 км	Алхдаг	13:00-14:00	1 цаг	
Гэр - Цэцэрлэг - Сургууль - Гэр	9 км	Алхдаг	16:00-18:00	2 цаг	

(Ц.Б, 31 настай, дэлгүүрт кассчин)

... Өглөө 8 цагаас гэрээсээ гараад 30 орчим минут алхаад хүүгээ цэцэрлэгт нь өгдөг. Ойрхон болохоор дандаа алхдаг. Өдөр охины хичээл 1 цагаас ордог. Хүүгээ хүргэж өгчихөөд охиноо сэрээгээд цай ундаа уугаад хувцас хунар гэсээр байгаад 11:30 гээд гэрээсээ гараад охиноо сургуульд нь хүргэдэг. 5 шар орчим яг түгжрэний бүс болохоор

эртхэн л гарахгүй бол амждаггүй. Хүргэж өгөөд ирээд нээх удалгүй хүүгээ цэцэрлэгээс нь 16:30-с аваад дараа нь охиноо очиж авнадаа. За ер нь өдөр ингэж л өнгөрч байна. Орой охиноо аваад гэртээ ирэхэд 19:00 өнгөрч байдаг.... (Өдрийн маршрутын зураглалыг дор харуулав).

Маршрут	Зай	Тээвийн хэрэгсэл	Хугацаа	Зарцуулж буй цаг	Нийт цаг
Гэр - Цэцэрлэг	2 км	Алхдаг	08:00-09:00	1 цаг	6 цаг 30 минут
Гэр - Сургууль	6 км	Автобус /5 буудал/	11:30-13:30	2 цаг	
Гэр – Цэцэрлэг -Сургууль – Гэр	8 км*2	Автобус	16:00-19:30	3 цаг 30 минут	

(А.Б, 31 настай, хувийн цэцэрлэгийн багш)

- Гэр-ажил-цэцэрлэг хоорондоо хэр зайтай байгаагаас хамаарч хүүхдээ цэцэрлэг, яслид хамруулж чадсан ч ажил-гэрийн ажлын зохицуулалт хийх боломжгүй нийтийн тээврийн хүртээмж болон замын түгжрэлээс шалтгаалан хүүхдээ цэцэрлэг, хүүхэд харах үйлчилгээнд хамруулж чадахгүйд хүрч, улмаар ажлаасаа гарсан байна.

...Би 2014-2017 онд Жанжин захад, ерөнхий зохицуулагчаар ажиллаж байсан. Манай ажил чулуун овоонд хүүхдийн цэцэрлэг төмөр замд байрлалтай байсан учраас их хол, ажлаас эрт гарахгүй л бол амждаггүй. Нийтийн тээврээр буудал болгон дээр зогсоод цаг их авна бас 2 дамжиж автобусанд сууж цэцэрлэг нь очдог. Хүүхдээ 16:30-аас авч амжихгүй бол цагийн 1,000 төгрөгөөр бодож нэмэгдэл төлнө. 2 хүүхэд гэхээр хөөрхөн хэдэн төгрөгийн нэмэгдэл төлөх болно.

(Н.М, 31 настай, Худалдааны захын ерөнхий зохицуулагч)

...Би жирэмсний амралтаа дуусгаад 2022 оны 9-р сараас буцаж ажилдаа орсон. Хүүгийн цэцэрлэг орой 17:30-д тардаг. Манай ажил орой 19:00-20:00 гэж тардаг. Хорооллын номин дэлгүүр дотор Түмэн торго салонд ажилладаг. Ажлаас цэцэрлэг хүртэл нь 17 орчим км. Тэгэхээр чинь яаж ч 17:30-д авч амжихав дээ. Хүүгээ аваад гэртээ харихад түгжрэл ихтэй бол 21:00 дөхүүлж харина. Би өөрөө иогийн багш хийдэг юм. Тэгээд цэцэрлэгийн багш нарт ажил нь эхлэхээс өмнө очиж иогийн хичээл ордог. Багш нартай гайгүй дотно болсон болохоор надаас нэмэлт хураамж нэхээд байдаггүй. Хэрвээ иогийн хичээл ороогүй бол ажлаа тарсны дараа очиж авна гэхээр төлбөр/хураамж өндөр төлөх болно...

(Б.Т, 39 настай, оёдолчин)

4.2 Үйлчилгээний чанар

Хэдийгээр нэг ангид хэт олон хүүхэд явж, бүлэг дүүргэлт өндөр байдаг ч эцэг эхчүүд хүүхдээ улсын цэцэрлэгт явуулах сонирхол,

эрмэлзлэл өндөр байна. Учир нь цэцэрлэгийн зориулалтын барилга, байгууламжтай, орчны стандарт хангагдсан, мэргэжлийн боловсон хүчин тогооч, эмч, биеийн тамирын болон дуу хөгжмийн багштай, харьцангуй олон хамт олонтой учраас үйл ажиллагаандаа, бие биедээ хяналт тавих, өрсөлдөх боломжтой зэрэг улсын цэцэрлэгт олон давуу тал байгааг судалгаанд оролцсон ээжүүд онцолж байна.

Хувийн цэцэрлэгүүдэд тулгамдаж байдаг хамгийн гол асуудал нь өөрийн барилга, байгууламж байхгүй, дийлэнх нь түрээсийн байранд үйл ажиллагаа явуулж байна. Бүлгийн хэмжээнээс хамаарч хувийн цэцэрлэгийн түрээсийн байр, байгууламжийн чанар стандарт харилцан адилгүй байна.

Цогц үйл ажиллагаа явуулж буй хувийн томоохон цэцэрлэгүүд, тэдгээрийн салбарууд улсын цэцэрлэгүүдээс ч илүү чанартай орчин, нөхцөл бүрдүүлсэн байхад айлын орон сууцны 1 давхарт үйл ажиллагаа явуулж буй хувийн олон цэцэрлэг орчны стандартад нийцэхгүй нөхцөлд үйл ажиллагаа, үйлчилгээ эрхэлж байна. Тухайлбал, тоглоомын талбай байхгүй, ариун цэврийн өрөөны багтаамж бага гэх мэт. Харин улсын цэцэрлэгийн байгууламж хүрэлцэхгүй байгаа тохиолдолд үйл ажиллагаагаа зогсоосон зориулалтын барилга, байгууламжтай хувийн цэцэрлэгийн байрыг түрээслэх арга хэмжээг улсаас санхүүжүүлж байна.

Хүүхдээ цэцэрлэгт хамруулж чадсан ч үйлчилгээний чанар муу, ачаалал их байгаагаас хүүхдийн өвчлөл өндөр, халдварт өвчний тархалтыг нэмэгдүүлж байна. Улмаар ээжүүд цалинтай ажил хийснээс хүүхдээ эрсдэл багатай гэрийн орчинд харж, асрах сонголт хийж байна.

Холоос хүүхдээ зөөдөг өрхүүдийн хувьд ковидын цар тахал, амьсгалын замын халдварт өвчний өндөр эрсдэлтэй үед нийтийн тээврээр үйлчлүүлэх нь эрсдэлтэй болсон тул хүүхдээ цэцэрлэгт хүргэж өгөх унааны зардал эрс нэмэгдсэн байна.

- Бидний сонгосон 4 эмэгтэйн 3-ынх хүүхдүүд улсын цэцэрлэгт, 1-ийнх нь хүүхэд харьяалалтай улсын цэцэрлэг оноолт таарсан хэдий ч гэр бүлийн хүчирхийллийн улмаас нөхрөөсөө салж хуваарьт цэцэрлэгт нь хүүхдүүдээ зөөх нь хүндрэл гарсан, улмаар одоо амьдарч буй оршин суугаа хаягтаа хүүхэд харах үйлчилгээнд хамруулсан байв. Гэвч

тус үйлчилгээнүүдийн чанар, хүртээмж харилцан адилгүй байгаа нь ээжүүдийн хөдөлмөр эрхлэлт болон өрхийн орлогод сөргөөр нөлөөлж байна.

...Хүүхэд харах үйлчилгээнд хамрагдсан хүүхдүүд маань ойр ойрхон өвдөөд эмнэлэгт хэвтээд байгаа болохоор цэцэрлэгт явуулж чадахгүй байна. Улсын цэцэрлэгийг бодвол арай хөтөлбөр нь муу сул санагдсан, бас зай талбай орчны хувьд улсын цэцэрлэгийг гүйцэхгүй.

Над шиг ганц бие ээжид хувийн цэцэрлэгт сар бүр төлбөр төлж хүүхдээ өгөх дарамттай байсан. Харин сая намар ашгүй улсын цэцэрлэгт хуваарилагдсан байсанд баярласан. Дээрээс нь орон зайн хувь, сургалтын хөтөлбөрийн хувьд ч арай илүү байгаа санагдсан...

(Н.М, 31 настай, Худалдааны захын ерөнхий зохицуулагч)

- Хэдийгээр цэцэрлэг, хүүхэд харах үйлчилгээнд хүүхдүүдээ хамруулж чадсан ч ханиад томуугийн үед хүүхдүүдийн дунд өвчлөл өндөр байгаа нь тогтмол цэцэрлэг, хүүхэд харах үйлчилгээнгээ хамрагдах боломжийг хязгаарлаж байна.

...Ханиад хүрлээ, эдгээлээ, буцаж явуулаад 7 ч хоног хүрэхгүй буцаад ханиад аваад ирнэ. Хамгийн хэцүү нь нэг хүүхэд ханиад хүрэхээр нөгөө 2 нь заавал хүрдэг. 2022 оны 12-р сараас цэцэрлэгээс нь чөлөө авч сурагчдын амралт дуустал буюу 2023 оны 1 сарын 30 хүртэл гэрээр асарсан.

Одоо хүүхэд өвдөөд ажлаа хийхгүй байгаа. Хүүхдээ аль болохоор өвчин тусгахгүй талаар эрүүл хүнс, эрүүл агаарт их гаргах гэж хичээгээд л Бэлхэд зусланд байдаг. Цэцэрлэгт явахаар хүү маань байнга ханиад хүрээд байдаг. Өвдсөн үед нь тусалж дэмжих хүн бид 2-т байхгүй болохоор би өөрөө ажлаа орхихоос өөр аргагүй байна. Хүүхэд өвдөхөд хамгийн багадаа 30,000₮, хүндэрвэл 200,000₮ даваад л явж өгнө. Хорооны эмнэлэгтээ үзүүлээд эм бичүүлдэг юм. Ер нь тэгээд улсын эмнэлэг оочир их болохоор хувийн эмнэлэгт бололцоотой үедээ очихыг боддог.


2022 оны 9-р сараас хүүгээ цэцэрлэгт өгсөн. Жирэмсний амралт дуусаад цэцэрлэгт өгөөд буцаад ажилдаа орсон. 2022 оны өвөл цэцэрлэгийн ханиад 11-р сараас эрс ихсээд 11 болон 12-р сард 7 хоногийн чөлөө авсан. Тэр хугацаанд өвөө эмээд нь 7 хоног гэртээ харуулсан. Хөгшин хүмүүс удаан хүүхэд харах боломжгүй өөрсдөө ядардаг. Тэгээд буцаад цэцэрлэгт нь явуулаад 10 хоног хүрэхгүй хугацаанд дахиад ханиад хүрсэн тул ажлаа хийх

боломжгүй болж хүүхдээ цэцэрлэгээс нь чөлөө аваад гэрээрээ харж байна. Ямар ч тохиолдолд цалинтай чөлөө гэж байдаггүй. Шууд л цалингаас хасна. Ажилгүй байгаа учраас тогтмол орлогогүй болсон...

(Хүүхдийн цэцэрлэгт хамрагдалтын талаарх календарчилсан зургийг дор харуулав).

(Э. 33 настай, ажил эрхлэлтээ зогсоож, хүүхдээ гэртээ харж байгаа)

2022 оны 9 дүгээр сараас 2023 оны 3 сар хүртэл цэцэрлэгт хамрагдсан байдал



Хүүхдийн өвчлөл нь ялангуяа өвлийн улиралд тухайн эмэгтэйд тогтвортой хөдөлмөр эрхлэх боломжийг хязгаарладагаас гадна өрхийн эрүүл мэндийн зардлыг нэмэгдүүлж байна.

Эрүүл мэндийн өндөр зардал үүсгэхийн оронд ажлаасаа гарч хүүхдээ асрах нь эдийн засгийн хувь арай ач холбогдолтой байгаа талаар ч ээжүүд онцолж байв (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Хүүхдийн өвчлөлт, өрхөөс гаргасан эрүүл мэндийн зардал

Код	Судалгааны нэгж	Хүүхдийн тоо	Хүүхэд нь жилд өвчилж буй давтамж – өвдсөн байгаа эсэх	Нэг удаагийн эмчилгээний зардал
Кейс 1	Хотын захад амьдардаг, СӨБ, хүүхэд харах үйлчилгээнд хүүхэд нь хамрагддаг	4	2 хүүхэд нь ойрхон хагалгаанд орсон.	200,000₮-300,000₮
Кейс 2	Хотын төвд амьдардан, СӨБ, хүүхэд харах үйлчилгээнд хүүхэд нь хамрагддаг.	3	Цэцэрлэгт нь явуулахгүй гэртээ харж байгаа. Ханиад хүрчихвэл бага дүүдээ халдаах өндөр эрсдэлтэй байсан.	-
Кейс 3	Хотын захад амьдардаг. СӨБ, хүүхэд харах үйлчилгээнд хүүхэд нь хамрагдаж байгаад больсон.	2	Одоо өвдсөн байгаа, цэцэрлэгт нь явуулахгүй гэртээ харж байгаа.	50,000₮ орчим
Кейс 4	Хотын төвд амьдардаг, СӨБ, хүүхэд харах үйлчилгээнд хүүхэд нь хамрагдаж байгаад больсон.	1	Ойрхон өвдөөд байгаа тул ажилаа хийлгүй зуслангийн аманд хүүхдээ эрүүл агаарт асарч байна.	30,000₮-200,000₮

4.3 Ажлаа тогтвортой үргэлжлүүлэхэд үзүүлж буй дэмжлэг

2018 оноос жирэмсэн эх, 3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эх, эцэг, дөрөв хүртэлх насны ихэр хүүхэдтэй эх, эцэг, гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгож эхэлсэн.⁴⁸ Хөдөлмөрийн хууль⁴⁹-иар хөхүүл хүүхэдтэй эмэгтэйг эмнэлгийн магадалгаанд заасан хугацаагаар өөр ажилд шилжүүлэх; хүүхэд асрах чөлөөтэй байгаа тохиолдолд ажлын байрыг хэвээр хадгалах; эмнэлгийн магадалгаа гарсан тохиолдолд хөхүүл хүүхэдтэй эмэгтэй ажилтны ажлын цагийг богиносгох; 3 хүртэлх насны хүүхэдтэй ажилтан өөрөө зөвшөөрөөгүй бол шөнийн болон илүү цагаар ажиллуулахыг хориглох; 3 хүртэлх насны хүүхэдтэй, эсвэл 16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилтан өөрөө зөвшөөрснөөс бусад тохиолдолд нийтээр амрах баярын болон долоо хоног бүрийн амралтын өдөр ажиллуулахыг хориглох, цаашлаад хүүхэд асрах чөлөөг 3 хүртэлх насны хүүхэдтэй бүх ээжүүд (ганц бие аав) авч болох⁵⁰ бөгөөд хөдөлмөр эрхлэлтийн харилцааг ажил олгогчийн санаачилгаар цуцлахыг хориглох зэргээр хөдөлмөрийн гэрээний нийтлэг зохицуулалт, харилцааг тусгайлан хуулиар хамгаалсан байдаг. Түүнчлэн, хүүхэд хөхүүлэх, асрах нэмэлт завсарлага олгох, түүнд олговор тооцох, 3 хүртэлх насны хүүхэдтэй ажилтан ажил үүргээ гэрээсээ, эсхүл зайнаас гүйцэтгэхээр ажил олгогчтой харилцан тохиролцож, уян хатан нөхцөлөөр ажиллуулах боломжийг нээсэн ба ажилтан өөрөө зөвшөөрснөөс бусад тохиолдолд албан томилолтоор ажиллуулахыг хориглосон.

Хүүхэд асрах чөлөөтэй байх хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг ажил олгогч ажилтан/ажилчны өмнөөс нийгмийн даатгалын санд төлдөг. 3 хүртэлх насны хүүхэдтэй аавууд хүүхэд асрах чөлөөг өөрөө хүсвэл авч болно.

- Хөдөлмөрийн тухай шинэ хуулинд эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн ээлтэй зохицуулалт орж ирсэн ч тухайн ажил олгогчийн зүгээс

хөдөлмөрийн уян хатан нөхцөл, хуулийн хэрэгжилтийг дагаж мөрдөхгүй байх, эсвэл бага насны хүүхэдтэй залуу эмэгтэйчүүдийг ажилд авахгүй байх хандлагатай байдгийг кейс судалгаа харуулж байна.

...Манайд бага насны хүүхэдтэй 4 эмэгтэй ажиллаж байгаагаас 2 нь ажил, гэр, цэцэрлэг нь 1 дор байдаг тул хүүхдээ зөөх, авахад хүндрэл учирдаггүй. Харин 2 эмэгтэй орон нутгаас ирсэн. Хүүхдүүдийг нь ээж, аав нь хардаг гэсэн. Тийм учраас ажлаас чөлөө авах, хоцрох асуудал гардаггүй. Манай байгууллага худалдааны салбарын хатуу цагт баригдаж ажилладаг компани. Анхнаасаа ажилд авахдаа тухайн ажилтны нас, хүйс болон бага насны хүүхэдтэй эсэхэд бид ялгаатай шалгуур тавьж авдаггүй, нээлттэй байдаг. Манай байгууллагын ажлын хуваарь, нөхцлийг хүлээн зөвшөөрч 2 талаар хөдөлмөрийн гэрээ байгуулдаг тул харьцангуй хүндрэл учирдаггүй. Гэвч бага насны хүүхдийн эрүүл мэндтэй холбоотой аливаа асуудал үүсвэл байгууллагын хүний нөөц зохицуулалтыг хийдэг...

(Б.Б, 45 настай, эрэгтэй, Хороон засаг дарга)

...Төрийн байгууллага бол хоцорсон секундээр цалин тооцдог. Маш хатуу. Чөлөө авах бол хүндэтгэн үзэх шалтгааныг бараг батлуулж ир л гэнэ байх. Төрийн байгууллагад хэзээ ч ажиллахгүй гэж боддог. Ялангуяа над шиг ганц бие ээж бол дорхноо халагдах байх. Хөдөлмөрийн гэрээн дээрээ ямар ч уян хатан нэмэлт юм байхгүй. Би төрийн цэцэрлэгт ажиллаж үзье гэж бодоод гэрээтэй нь танилцаж байсан. 3 удаа хоцорвол сануулга өгнө түүнээс дээш бол шууд хална гэж байх жишээтэй. Тэгтэл цэцэрлэгийн цаг ажлын цаг 2 давхцаж байгаа нь цэцэрлэгийн насны хүүхэдтэй залуу ээжүүд гэртээ суу гэсэнтэй яг адилхан л утгатай байдаг.

2014-2017 онд “Суман гүн” ХХК-ий охин компанид ажилладаг байсан. Намайг бага насны 2 хүүхэдтэй гээд их ойлгодог байсан, цалингаа ч бүтэн авдаг байсан. Би хийх ажлаа шахаад яг хийдэг хариуцлага алдаж байгаагүй болохоо захирал маань ойлгодог байсан. Тэрнээс байгууллагын дотоод дүрэм журам, хөдөлмөрийн гэрээний дагуу бол цалингаа бүтэн авах боломжгүй. Захирал маань ойлгодоггүй байсан бол би ажил хийх боломжгүй байсан л даа. Захиралдаа их баярладаг...

(Н.М, 31 настай, Худалдааны захын ерөнхий зохицуулагч)

⁴⁸ УИХ-аас 2017 онд “Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хууль”-ийг батлан, 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжүүлсэн.

⁴⁹ Монгол улс Хөдөлмөрийн тухай хуулийг 1930, 1933, 1934, 1941, 1973, 1991, 1999 онд батлан, тухайн цаг үеийн нийгэм, эдийн засгийн өөрчлөлттэй уялдуулан хөдөлмөрийн харилцааны асуудлыг зохицуулж иржээ. Тус хуулийг 2021 онд шинэчлэн найруулж, 2022 оны 1 сарын 1-нээс хэрэгжиж эхлээд байна.

⁵⁰ “Хүүхэд асрах чөлөө”-г хуульчилж, хугацааг тогтоож өгсөн.

5. САНАЛ ЗӨВЛӨМЖ

Кейсийн түүх, баримт бичгийн судалгаанд үндэслэн дараах санал, зөвлөмжийг гаргаж гарна. Үүнд:

1. Ажил-гэр-цэцэрлэгийн хоорондын зай, нийтийн тээврийн хүртээмжгүй байдал, замын түгжрэл нь эмэгтэйчүүдийн ажил эрхлэх боломжийг хязгаарлаж байна. Иймд,
 - Байгууллагын дэргэдэх цэцэрлэгүүдийн тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна. Улсын цэцэрлэгүүд өөрийн салбарыг байгуулах замаар байгууллагуудад дэмжлэг үзүүлж байгаа бөгөөд цэцэрлэгийн бүхий л үйл ажиллагаа стандартын дагуу явагдах боломжтой хамгийн оновчтой хувилбар байж болохоор байна. Ажил эрхэлдэг ээж, аавуудад нэгэн адил энэ нь хамгийн эрэлттэй хувилбар гэдэгт итгэлтэй байна.
 - Алслагдмал бүс нутаг, малчид, гэр хороолол, шилжигч хүн ам, ядуу, эмзэг хүн амд чиглэсэн СӨБ-ын хөтөлбөрүүдийг улам боловсронгуй болгох, орон нутгийн иргэдийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, ердийн болон хувилбарт цэцэрлэг-сургалтын хүртээмжийг нэмэгдүүлж, чанарыг дээшлүүлэх шаардлагатай байна. Ийм санал санаачлага гаргасан орон нутгийн удирдлага, байгууллага, хувийн хэвшилд санхүү, хөрөнгө оруулалт, зээлийн дэмжлэгийг эн тэргүүнд эрэмбэлэн олгох нь чухал юм.
2. Цэцэрлэг, хүүхэд харах үйлчилгээний чанар⁵¹-ыг сайжруулахгүйгээр тэдгээрт хамрагдаж буй хүүхдүүдийн дунд тархаж буй халдварт өвчний түвшин, давтамжийг бууруулах боломжгүй байна. Иймд,
 - СӨБ-ийн багш, сурган хүмүүжүүлэгчийн тоог нэмэгдүүлж, ачааллыг багасгах, стандартын дагуу эмч, биеийн тамирын багш нарыг ажиллуулах нөхцөлийг бүрэн хангах
 - Үйлчилгээний чанарыг дээшлүүлэхийн тулд орон нутгийн ялангуяа сум, дүүргийн захиргааны зөвлөлд цэцэрлэгийн эрхлэгчдийн төлөөллийг оролцуулах шаардлагатай. Орон нутгийн төсөв хуваарилах, шийдвэр гаргахад эдгээр албан тушаалтны дуу хоолой нэн чухал байна.
3. Шинээр дагаж мөрдөж буй хөдөлмөрийн хуулийн холбогдох заалтыг нарийвчлан хэрэгжүүлэх, зөрчил гарсан тохиолдолд гомдол барагдуулах механизмыг бий болгон ажиллах чиг үүргийг ажил олгогчид, ажиллагсдын эрх ашгийг хамгаалах төлөөлөл, байгууллага /үйлдвэрчний эвлэл, жендэрийн зөвлөл, эмэгтэйчүүд, эцэг эхийн зөвлөл гэх мэт/-уудтай хамтран хэрэгжүүлэх, хянах, тайлагнах шаардлагатай байна. Үүний тулд,
 - Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хотод цэцэрлэг, сургуулиас хүүхэд зөөдөг үйлчилгээ, хүүхэд түр харах үйлчилгээг шинээр нэмэх, санхүүжилтийг хүртээмжтэй хуваарилж, батлах
 - Дээрх хөтөлбөрөөр дамжуулан ур чадвар олгох цахим болон танхим сургалтууд зохион байгуулах, мэргэжлийн болон ТББ-уудыг татан оролцуулж, дэмжлэг авах
 - Зайны болон цагийн ажилд зуучлах үйлчилгээг хөдөлмөрлөх эрхийн мэдрэмжтэй болгох, сургалт болон сэтгэл зүйн зөвлөгөөг хамт үзүүлж байх
 - Зайнаас ажиллаж болох ажлын зарын талбар үүсгэн, олон нийтэд илт тод мэдээллэх, түгээх
 - Хөдөлмөрийн гэрээ, дотоод дүрэм журамд охид, эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрхийн эсрэг зүйл заалт орсон эсэхэд хяналт үнэлгээ хийж, холбогдох зөвлөмж шаардлага хүргүүлэх

⁵¹ Нэг багшид ногдох хүүхдийн тоо, биет дэд бүтэц, аюулгүй байдал/эрүүл мэндийн стандарт, үйлчилгээний орчин, хүүхдийн насны онцлогт тохирсон сургалтын орц, багш, эцэг эх, асран хамгаалагчийн хоорондын зөрэг харилцаа холбоо гэх мэт.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

Монгол Улсын хууль, Монгол Улсын Үндсэн хууль, 1992

Монгол Улсын хууль, Боловсролын тухай хууль, 2002

Монгол Улсын хууль, Хөдөлмөрийн тухай хууль (шинэчилсэн найруулга) 2021

Монгол Улсын хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, 2011

Монгол Улсын хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, 2008

Монгол Улсын хууль, Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль, 2015

Монгол Улсын хууль, “Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай” 2017

Монгол Улсын хууль, Алсын хараа-2050, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2020

Монгол Улсын Их хурлын тогтоол, 2020, дугаар 24, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр

ҮСХ, 2020. Цартахлын бизнесүүдэд үзүүлж буй нөлөө, 2-р шат. Үндэсний статистикийн хороо, Улаанбаатар

ЭЗХАХБ, 2019. Нийгмийн институци ба жендэрийн индекс. Retrieved from www.genderindex.org

Цахим хуудас

<https://www.1212.mn/mn/statistic/file-library/view/47812001>

Statistical news of the preschool education sector, meds.gov.mn/post/64832

UNHABITAT, Urbanization, <https://ourworldindata.org/urbanization>

ҮСХ, Нэгдсэн мэдээллийн сан, <http://1212.mn>